



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг, 60 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэхь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11:30 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, санал авах хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, хурлын мэдэгдлийг гуравдугаар хавсралтаар, хурлын зарыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Дарга: Д.Урангуа – компанийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд: М.Сауле – компанийн горим тооцооны инженер
Л.Батцэцэг – компанийн эдийн засагч

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Насантогтохыг сонгосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр тус тус тогтоосугай.



ДАРГА

П.ДАВААДОРЖ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
3 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

1. Компанийн 2021 оны тайлан тэнцлийг аудитаар шалгагдсан дүнгийн тухай
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ажлын тайлан, 2022 оны зардал батлах тухай;
4. Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд, хараат бус гишүүдийг сонгож батлах тухай;
6. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийн тухай;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлын тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



**“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
САНАЛ АВАХ ХУУДАС**

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11:30 цагт “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд болов.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар	
Хувьцаа эзэмшигчийн мэйл хаяг	
Регистрийн дугаар	
Эзэмшиж буй хувьцааны тоо	

Санал хураах арга: Энгийн

№	Санал авах асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн	Татгалзсан эсвэл түтгэлзсэн тохиолдолд өгөх санал
1	Компанийн 2021 оны аудитлагдсан тайлан тэнцлийн дүнгийн тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
2	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ажлын тайлан, 2022 оны зардал батлах тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
4	Ногдол ашгийн тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
5	Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд, хараат бус гишүүдийг сонгож батлах тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
6	Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийн тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
7	Бусад асуудал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Заавар: Та өөрийн саналыг + тэмдгээр бичнэ үү.

Хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Нэр.....
Албан тушаал.....
Гарын үсэг.....
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг \.....\

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Комиссын дарга: / Д.Урангуа –ЗУХ-ийн дарга/

Гишүүд: /М.Сауле –Горим тооцооны инженер/

..... /Л.Батцэцэг-Эдийн засагч /

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

.....



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар
тогтоолын гуравдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Дулаан шарын гол” ТӨХК
Хаяг:	Дархан-Уул аймаг Шарын гол сум
Хурал хуралдах өдөр, цаг:	2022.04.27-ны өдөр, 11:30 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Эрчим хүчний яам /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр / цахимаар
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2022.03.17
Олон нийтэд зарлах огноо:	2022.03.22
Бүртгэлийн өдөр:	2022.04.11
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2022.03.20
Хүргүүлсэн огноо:	2022.03.20
Хурлын даргын нэр:	Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Комиссын дарга : Д.Урангуа Комиссын гишүүд: М.Сауле Л.Батцэцэг
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	- Хурал хуралдуулах тухай шийдвэр - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар - Саналын хуудасны загвар - Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа
Баримт бичгийн хуудасны тоо: хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
3 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар
тогтоолын дөрөвдүгээр хавсралт

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр:

“Дулаан шарын гол” ТӨХК

Хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:

“Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11:30 цагт

Бүртгэлийн өдөр:

2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны тайлан тэнцлийг аудитаар шалгагдсан дүнгийн тухай
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ажлын тайлан, 2022 оны зардал батлах тухай;
4. Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд, хараат бус гишүүдийг сонгож батлах тухай;
6. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийн тухай;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэцүүлэхээр оруулсан бусад асуудлын тухай

Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 09:30- 17:30 цагийн хооронд 88703065 утсаар болон “Дулаан шарын гол” ТӨХК-ийн төв байранд ирж ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно. Мөн цахим хэлбэрээр авч танилцаж болно.

Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ХЭХ хуралдуулах шийдвэр
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
5. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Нэр дэвшүүлэх түр хороо
байгуулах тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.1, 81.5.1, 81.5.3 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэр дэвшүүлэх түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Түр хорооны дарга: С.Ариунболд
Гишүүд: Г.Гэрэлт-Од
Н.Ган-Эрдэнэ

2. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомж, журам, дүрмийн дагуу зохион байгуулж, нэр дэвшигчдийн үнэлгээний жагсаалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэхийг Нэр дэвшүүлэх түр хорооны дарга /С.Ариунболд/-д үүрэг болгосугай.



ДАРГА

П.ДАВААДОРЖ